



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 19 өдөр

Дугаар А/100

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 сарын 24-ны өдрийн 2/06 тоот тогтоол, аймгийн Онцгой комиссын 2020 оны 28 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хэрэгцээний нөөцийн мах бэлтгэн нийлүүлэхээр шууд гэрээ байгуулан ажиллаж байгаа “Монголиан каттл” ХХК-д гэрээний дагуу санхүүжүүлэх 120.000.000 /нэг зуун хорин сая/ төгрөгийг олгосугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 120.000.000 /нэг зуун хорин сая/ төгрөгийг аймгийн барьцаа хөрөнгийн 100160051301 тоот дансанд татан төвлөрүүлсэн орлогоос гэрээнд баталсанаар санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ